



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Андсайхан” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/175/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ Утас: 99110699 Цахим хаяг: <a href="mailto:munkhtsatsral@cmdaudit.mn">munkhtsatsral@cmdaudit.mn</a> Аудитор: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyam1202@gmail.com">tseenyam1202@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
ГУРАВ.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1 Албан шаардлага .....	6
3.2 Зөвлөмж.....	6
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	8
4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл .....	8

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15

№

585

танай

-ны №

-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН АНДСАЙХАН ӨЭМТ-ИЙН  
ДАРГА Н.ЭЛБЭГТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Андсайхан ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Андсайхан ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 582.4 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 149.1 сая төгрөгийн, 6 настны шүдний үзлэгийн төлбөрийн 0.6 сая төгрөгийн нийт 732.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний

биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.1 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 95.2 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1. ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,007,536.90	5,086,128.72
1.1.2 Дансны авлага	35,798,269.26	9,432,425.80
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4 Бусад авлага	1,024,000.00	-
1.1.5 Бараа материал	44,760,005.87	35,372,723.58
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	88,589,812.03	49,891,278.10
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	135,009,103.13	114,596,143.40
1.2.2 Биет бус хөрөнгө	-	-
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	135,009,103.13	114,596,143.40
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>223,598,915.16</b>	<b>164,487,421.50</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.3 Татварын өр	10,024,000.00	24,853,009.70
2.1.1.4 НДШ - ийн өглөг	20,000,000.00	21,612,470.78
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	70,228,233.75	55,424,916.25
бусад	-	192,000.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	100,252,233.75	102,082,396.73
2.2 Өр төлбөрийн нийт дүн	100,252,233.75	102,082,396.73
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	250,000.00	250,000.00
2.3.1.1 төрийн	-	-
2.3.1.2 хувийн	250,000.00	250,000.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,410,700.00	2,410,700.00
2.3.6 Эздийн өмчийн бусад хэсэг	49,343,877.70	49,343,877.70
2.3.7 Хуримтлагдсан ашиг	71,342,103.71	10,400,447.07
2.3.9 Эздийн өмчийн дүн	123,346,681.41	62,405,024.77
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>223,598,915.16</b>	<b>164,487,421.50</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	1,289,000.00	1,270,000.00
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг ( алдагдал)	1,289,000.00	1,270,000.00
4. Санхүүжилтийн орлого	786,770,066.65	732,086,416.30
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,691,575.13	23,221,523.31
7. Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8. Бусад орлого	18,232,831.30	8,557,710.23
9. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10. Ерөнхий ба удирдлагын зардал	814,157,474.92	826,032,706.48
11. Санхүүгийн зардал	24,000.00	44,600.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	22,801,998.16	(60,941,656.64)
19. Орлогын татварын зардал	-	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	22,801,998.16	(60,941,656.64)
22. Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	22,801,998.16	(60,941,656.64)
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	22,801,998.16	(60,941,656.64)

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого	-	-	-	-	-
2. Залруулсан үлдэгдэл	250,000.00	2,410,700.00	49,343,877.70	48,540,105.55	100,544,683.25
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	22,801,998.16	22,801,998.16
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	250,000.00	2,410,700.00	49,343,877.70	71,342,103.71	123,346,681.41
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
10. Залруулсан үлдэгдэл	250,000.00	2,410,700.00	49,343,877.70	71,342,103.71	123,346,681.41
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(60,941,656.64)	(60,941,656.64)
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	250,000.00	2,410,700.00	49,343,877.70	10,400,447.07	62,405,024.77

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>795,466,669.39</b>	<b>768,279,969.99</b>
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4 Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	624,468,894.39	583,210,534.76
1.1.6 Бусад мөнгөн орлого	170,997,775.00	185,069,435.23
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>769,528,957.48</b>	<b>768,201,378.17</b>
1.2.1 Ажиллагчдад төлсөн	540,915,952.00	517,757,988.00
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	108,397,277.14	122,029,147.53
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	55,632,726.50	50,848,316.80
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	2,943,367.00	3,273,000.00
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,000,000.00	3,120,000.00
1.2.6 Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	44,355,754.84	40,237,020.84
1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	89,100.00	106,920.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	15,194,780.00	30,828,985.00
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>25,937,711.91</b>	<b>78,591.82</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
<b>2.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>22,636,800.00</b>	<b>2,000,000.00</b>
2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	22,636,800.00	2,000,000.00
<b>2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(22,636,800.00)</b>	<b>(2,000,000.00)</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
<b>4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>3,300,911.91</b>	<b>(1,921,408.18)</b>
<b>5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,706,624.99</b>	<b>7,007,536.90</b>
<b>6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,007,536.90</b>	<b>5,086,128.72</b>

## ГУРАВ.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 43,473.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч албан шаардлага хүргүүлэн, санхүүгийн тайлагналтай холбоотой 33,629.4 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс санхүүгийн тайлагналтай холбоотой 33,629.4 мянган төгрөгийн зөрчил нь удирдлагын шийдвэр гаргахад нөлөөлөх нөлөөлөл бага, материаллаг бус тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

1. Байгууллагын даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар ажиллагсад сар бүр утасны нэгжийн үнэ 20.0 мянган төгрөгийг цалин дээр нэмж олгохоор шийдвэр гаргаж цалингийн зардлаас нийт 4,010.0 мянган олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл Бусад тусламж; 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1-д “үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цалингийн зардлаас утасны нэгж олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 39,463.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” заалтад заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-1. Тус байгууллагын нярав эм, бараа материалын зарцуулалтын тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулдаггүй, эхний 6 сарын байдлаар 33,629.4 мянган төгрөгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” заалтад заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмийн зарцуулалтын тайланг сар бүр гарган үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, санхүүгийн тайланг зөв илэрхийлж нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлд тусган баталгаажуулж, тайлагнаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын нярав эм, бараа материалын зарцуулалтын тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулдаггүй, эхний 6 сарын байдлаар 33,629.4 мянган төгрөгийн тайланг нэгтгэн тайлагнасан.	1	33,629.4	-	-	-	-	1	33,629.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>33,629.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>33,629.4</b>

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 39,463.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	39,463.6	1	39,463.6		-
Байгууллагын даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар ажиллагсдад сар бүр утасны нэгжийн үнэ 20.0 мянган төгрөгийг цалин дээр нэмж олгохоор шийдвэр гаргаж цалингийн зардлаас нийт 4,010.0 мянган олгосон байна.	1	4,010.0	1	4,010.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>43,473.6</b>	<b>2</b>	<b>43,473.6</b>		<b>-</b>

### Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлөгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөөс татгалзсан	
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНӨҮГ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 276/151170235

Улаанбаатар хот

НТАГ-2026/175/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Андсайхан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар ажиллагсад сар бүр утасны нэгжийн үнэ олгохоор шийдвэр гаргаж цалингийн зардлаас нийт 4,010,000.0 (дөрвөн сая арван мянган) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12-д "Бусад тусламж", 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-д "үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Цалингийн зардлаас утасны нэгжний үнийг олгосон 4,010,000.0 (дөрвөн сая арван мянган) төгрөгийг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Андсайхан Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Н.Элбэгтуяа, нягтлан бодогч Ё.Должинсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426790468



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 277/Б/1770235

Улаанбаатар хот

НТАГ-2026/176/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Андсайхан Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 39,463,636.0 (гучин есөн сая дөрвөн зуун жаран гурван мянга зургаан зуун гучин зургаан) төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Андсайхан Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Н.Элбэгтуяа, нягтлан бодогч Ё.Должинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090466